



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 278

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан нийт 78,213,502,382.50 (далан найман тэрбум хоёр зуун арван гурван сая таван зуун хоёр мянга гурван зуун наян хоёр төгрөг тавин мөнгө) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчит байгууллага болон орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, Чингис хаан музейн захирал, академич С.Чулуун, Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат нарт болон хавсралтад заасан аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020-2021 онуудад барьж ашиглалтад оруулсан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002547

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
138 дугаар тогтоолын хавсралт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон,
төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Барилга байгууламж ашиглалтад оруулсан улсын комиссын актын дугаар	Хүлээн авч бүртгэх аймаг, төрийн өмчит байгууллага
1	Соёлын төвийн барилга /Баянхонгор, Баянлиг сум/	2021.12.30	1,636,161,813.00	2021/54	Баянхонгор аймаг, ОНӨ
2	Орон нутаг судлах музейн барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2021.09.02	2,549,630,115.00	26/2021	Хэнтий аймаг, ОНӨ
3	Соёлын өвийн төвийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2021.07.02	4,254,189,216.00	БА-124/2021	Соёлын өвийн үндэсний төв
4	Соёлын төвийн барилга, 240 суудал /Сүхбаатар, Уулбаян сум/	2021.11.18	1,499,999,367.00	СҮ-017/21	Сүхбаатар аймаг, ОНӨ
5	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Галуут сум/	2021.08.12	1,871,346,678.50	2021/17	Баянхонгор аймаг, ОНӨ
6	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Заг сум/	2020.10.19	201,269,130.00	2020/36	Баянхонгор аймаг, ОНӨ
7	Соёлын төвийн барилга, 240 суудал /Сүхбаатар, Халзан/	2019.12.06	72,811,932.00	СҮ-017/19	Сүхбаатар аймаг, ОНӨ
8	Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Баян-Уул сум/	2021.12.15	1,681,408,026.00	95/2021	Дорнод аймаг, ОНӨ
9	Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Гурванзагал сум/	2021.11.08	1,430,216,400.00	70/2021	Дорнод аймаг, ОНӨ
10	Соёлын төвийн барилга, 250 суудал /Дундговь, Өлзийт/	2021.11.10	1,257,602,263.00	16/2021	Дундговь аймаг, ОНӨ
11	Соёлын төвийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Даваат баг/	2020.12.23	1,000,000,000.00	40/20	Орхон аймаг, ОНӨ
12	Соёлын төвийн барилга, 280 суудал /Өмнөговь, Баяндалай сум/	2020.09.24	300,000,000.00	У-2020/86	Өмнөговь аймаг, ОНӨ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Барилга байгууламж ашиглалтад оруулсан улсын комиссын актын дугаар	Хүлээн авч бүртгэх аймаг, төрийн өмчит байгууллага
13	Соёлын төвийн барилга, 400 суудал /Сэлэнгэ, Баянгол сум/	2020.09.14	205,752,286.00	БУ-82/2020	Сэлэнгэ аймаг, ОНӨ
14	Соёлын төвийн барилга, соёлын заал, 400 суудал, номын сан, 45 суудал /Дундговь, Эрдэнэдалай сум/	2021.12.01	1,564,279,499.00	19/2021	Дундговь аймаг, ОНӨ
15	Соёлын төвийн өргөтгөл, их засвар /Баянхонгор, Бөмбөгөр сум/	2020.08.26	83,561,399.00	2020/32	Баянхонгор аймаг, ОНӨ
16	Чингис хаан музейн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2021.12.24	58,605,274,258.00	БА-287/2021	Чингис хаан музей
	НИЙТ ДҮН		78,213,502,382.50 (далан найман тэрбум хоёр зуун арван гурван сая таван зуун хоёр мянга гурван зуун наян хоёр төгрөг тавин мөнгө)		